

ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ: ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Монгол Улсын Засгийн газар 2021 оны 1-р улиралд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг (“Мэдээлэл хамгаалах тухай хууль”) боловсруулж олон нийтэд танилцуулжээ. Уг хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганд өргөн барьж хэлэлцүүлэх аж.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсад бие даасан мэдээлэл буюу өгөгдөл (data) хамгаалах тухай хууль байгаагүй бөгөөд 1995 оны Хувийн нууцын тухай хууль, мөн Монгол Улсын байгууллагын нууцын тухай хууль болон тодорхой салбаруудын (эрүүл мэнд, санхүү) мэдээлэл хадгалах, дамжуулахтай холбоотой зохицуулалтуудын хүрээнд өгөгдөл, мэдээлэл хамгаалах эрх зүйн орчин бүрдэж байсан байна.

Хууль зүй дотоод хэргийн яамны зүгээс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж, санал шүүмжлэлийг нь тусгах зорилгоор цахим хуудсандаа нийтэлж танилцуулжээ. Ашигийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ)-ийн хувьд уг хуулийн төслийн албан бус Англи орчуулгыг хүлээн авсан бөгөөд Монголын хамтран ажиллагч байгууллагуудын хүсэлтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувийн нууцтай холбоотой олон улсын холбогдох хууль тогтоомж, стандартууд болон шилдэг туршилагуудад үндэслэн дүн шинжилгээ хийснээ танилцуулж буйг хүлээн авна уу.¹ Энэхүү дүн шинжилгээнд олон улсын стандарт, тэдгээртэй холбогдон бий болж буй сайн туршилагатай харьцуулахад анхаарал татахуйц зарим заалтыг онцлон авч үзсэн болно.

Хуулийн төслийн зарим заалтын талаарх хураангуй дүгнэлт

АТБХОУТ-ийн зүгээс хуулийн төсөлд дараах зохицуулалтууд туссан байгааг сайшаан дэмжиж байна. Үүнд:

¹ Энэхүү дүн шинжилгээнд хуулийн төсөлтэй холбоотой бүх асуудлыг хамруулан авч үзэх боломжгүй бөгөөд зөвхөн иргэний гол эрхүүдтэй холбогдох зарим заалтыг онцлон авч үзсэнийг анхаарна уу. Үүнтэй холбоотой мэдээлэл хамгаалах асуудлаар мэргэшсэн мэргэжилтнүүд болон иргэний нийгмийн байгууллагуудаар хуулийн төслүүдийг хэлэлцүүлэн, санал шүүмжлэл өрнүүлэх нь зүйтэй гэж зөвлөж байна.

- **Олон улсын гэрээ, хүний эрхийн хууль тогтоомжид үндэслэсэн байдал.** Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд хэрэв уг хууль олон улсын гэрээнд заасантай зөрчилдвөл олон улсын гэрээний заалт нь давж үйлчлэх тухай (2 дугаар зүйл), мөн түүнчлэн олон улсын гэрээнд заасан хувь хүний эрх, эрх чөлөөг (15.2 дугаар зүйл) хүндэтгэн үзэж, хамгаалах талаар тусгажээ. Үүнээс гадна хувийн мэдээллийг хамгаалах, ашиглахад хүний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх (5.1 дүгээр зүйл) зарчмыг тусгасан байгаа нь ач холбогдолтой болжээ.
- **Хувь хүний зөвшөөрөл болон мэдээллийн эзэн өөрийн мэдээллийг устгуулах эрхтэй холбоотой ерөнхий заалт.** Мэдээлэл хамгаалах тухай хуулиуд нь тодорхой заасан зарим нөхцөлийг эс тооцвол (доороос үзнэ үү) ерөнхийдөө мэдээллийн эзний зөвшөөрлийг үндэслэн хувийн мэдээллийг цуглуулж ашиглах шаардлагыг тусгасан байдаг. Түүнчлэн мэдээллийн эзэн хувийн мэдээллээ устгуулахаар хүсэлт гаргах боломжоор хангагдах ёстой. Үүнд холбогдох заалтууд хуулийн төсөлд туссан байна (Хуулийн төслийн 15.1.4 дэх хэсэг).
- **Гомдол шийдвэрлэх механизм ба Хүний эрхийн үндэсний комиссын оролцоо.** 23 дугаар зүйлд Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисст харьяалуулжээ. Хяналт тавих байгууллагын хараат бус байдал, хянан шалгах эрх мэдэл нь маш чухал бөгөөд хараат бус хяналтын механизмыг хангалттай түвшинд бүрдүүлэх нь олон улсын сайн туршлагад нийцнэ. Хуулийн төслийн 21.3-т мэдээллийн эзэн өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхийг мөн тусгаж өгсөн байна.

Дээрх зүйл, заалтуудыг хуулийн төсөлд тусгасан байгаа нь сайшаалтай боловч АТБХОУТ-ийн зүгээс хуулийн төслийн дараах заалтууд нь хүний халдашгүй байх эрх, түүнд хамаарах хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудалд хүндрэл учруулах нөхцөл үүсгэж болзошгүй гэж үзэж байна. Үүнд:

- **Хувийн мэдээллийг ашиглах зорилгыг хэт өргөн, ерөнхий байдлаар томъёолжээ.** Тус хуулийн 7.1, 7.2-т төрийн байгууллагууд хүний хувийн мэдээллийг цуглуулж боловсруулж ашиглаж болох хэд хэдэн нөхцөлийг заажээ. Үүнд “гэрээ байгуулах”, “хуульд заасан бол”, “үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах”, “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх” гэх мэт нөхцөлүүд багтаж байна. Эдгээр нь хэт өргөн хүрээтэй зорилго, үндэслэл байх бөгөөд дурын аливаа тохиолдлыг дээр дурдсан үндэслэлд хамааруулан тайлбарлаж болохоор байна. Жишээлбэл, терроризмын болзошгүй аюул заналхийлж буй нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нэрийн дор хүмүүсийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг цуглуулах боломж нээлттэй

байна. Ийм өргөн агуулгатай зорилго нь өгөгдлийг хамгаалах олон улсын сайн туршлагатай нийцэхгүй бөгөөд тодорхой бүлгийг тусгайлан авч үзээгүй, зохих зөвшөөрөлгүй, хувийн нууцыг хамгаалах баталгаа өгөлгүйгээр хүний хувийн мэдээллийг бөөндөн цуглуулах үйлдэл дахин давтан гарах байдалд хүргэж болзошгүй юм.

- **Тодорхой бус хуулийн үндэслэл хэд хэд заалтад туссан байна** (“хуульд заасан бол” гэх мэт). Хуулийн төсөлд “хуульд заасан бол” гэх үндэслэлээр хүний хувийн мэдээллийг цуглуулж боловсруулж ашиглаж болохоор тусгаж зохицуулжээ (тухайлбал, 7.1.1, 7.2.1, 8.1.1, 9.2.1-2-ыг үзнэ үү). Энэ нь чухам ямар хууль/зүйл заалтыг хамааруулж байгаа нь хуулийн төслөөс үзэхэд тодорхой биш байна. Цаашилбал ийм бүдэг бадаг, тодорхойгүй заалт нь мэдээлэл цуглуулагч дурын хуулийг үндэслэл болгон ашиглаж хувь хүний ямар ч мэдээллийг цуглуулж, боловсруулан, ашиглах үүд хаалгыг нээх эрсдэл бий болгожээ. Ийм тодорхой бус заалт нь хувь хүний мэдээллийг хамгаалах бус харин ч мэдээллийг нууцлалгүй болгож, улмаар хувийн мэдээллийг зохих хамгаалалтгүйгээр бөөнөөр нь цуглуулах, боловсруулах магадлал үүсгэж байна.
- **Биометрик мэдээллийн хэрэглээг хэт өргөн байхаар тусгасан байна.** 10-р зүйл нь цахим хэлбэрээр сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хилээр нэвтэрч байгаа хувь хүнийг таних, баталгаажуулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх, мөн түүнчлэн, эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх шинжилгээ хийхэд ашиглах зорилгоор гэх мэтчилэн хувь хүний дахин давтагдашгүй биометрик мэдээллийг (хурууны хээ) цуглуулж ашиглах нөхцөлийг өргөн хүрээтэй тогтоожээ. Ийнхүү өргөн цар хүрээтэй нөхцөлүүд заахдаа “мэдээллийн эзний зөвшөөрлийг үндэслэх” гэж заасан боловч мэдээллийн эзэн сонгуульд санал өгөх, хилээр нэвтрэх, эрүүгийн болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хурууны хээ өгөхөөс татгалзах боломжоор хангагдах эсэх нь тодорхойгүй байна. Тодруулбал “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” зорилгоор биометрик мэдээллийг цуглуулна гэсэн нь аливаа гэмт хэрэг гарахаас өмнө буюу гэмт хэрэг болоогүй байхад тодорхой хувь хүн, хүмүүсийн дахин давтагдашгүй мэдээллийг цуглуулах, хадгалах боломж, гарцыг нээж байна. Ийм төрлийн дахин давтагдашгүй өгөгдлийг цуглуулах, хадгалах, ашиглах болон түүнтэй холбогдох үйл ажиллагаанд хяналт тавихын тулд хүний эрхийг хамгаалах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлсэн байх нь чухал. Эс бөгөөс олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрхийг зөрчих нөхцөл үүсэж болзошгүй байна.² Биометрик мэдээллийг олон нийтийн ашиг сонирхлыг хангахад

² See, e.g., Use of Biometric Data to Identify Terrorists: Best Practice or Risky Business?, Report prepared under the aegis of the Mandate of the Special Rapporteur on the promotion and protection of human rights and fundamental freedoms while countering terrorism Dr. Krisztina Huszti-Orbán and Prof. Fionnuala Ní Aoláin, <https://www.ohchr.org/Documents/Issues/Terrorism/biometricsreport.pdf>, at 9.

зайлшгүй шаардлагатай нөхцөлд болон мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр цуглуулж, ашиглах ёстой юм.³

- **Мэдээллийн эзэн буюу иргэдэд үүрэг оноожээ.** Хуулийн төслийн 16-р зүйлийн 16.1 дэх хэсэгт мэдээллийн эзэн буюу иргэд өөрт хамааралтай мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, алдаатай мэдээллийн талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэх үүрэгтэй болохыг заажээ. Ингэснээр мэдээллээ ашиглуулж буй этгээдэд тухайн мэдээллийн үнэн зөв байдал болон ашиглахтай холбоотой үүрэг хариуцлага хүлээлгэжээ. Энэ нь талуудын хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг ойлгомжгүй болгож байна. Тухайлбал, аливаа этгээд бүх тохиолдолд “үнэн зөв” мэдээлэл ашиглах үүрэг хүлээх ёсгүй юм. Жишээлбэл, нийгмийн сүлжээнд нэрээ нууцлах, эсвэл зохиомол нэр ашиглахыг олон улсын эрх зүйн хүрээнд зөвшөөрсөн байдаг. Тиймээс ийм нөхцөлд үнэн зөв биш мэдээлэлтэй холбогдуулж аливаа хэлбэрээр хариуцлага хүлээлгэх нь зохисгүй юм.
- **Хянах төхөөрөмжийг хэрэглэх хүрээ нэмэгдэхээр байна.** Хуулийн төслийн 26-р зүйлийн 26.3 дахь хэсэгт орон сууц, нийтийн зориулалттай орон сууцны орох, гарах нийтийн хэсэг, дундын эзэмшлийн талбай, ажлын байр, замын хөдөлгөөний хяналтад дууны, дүрсний, дуу-дүрсний төхөөрөмж байрлуулахыг зөвшөөрчээ. Хэрэглээний хувьд эдгээр нь зүй ёсны байж болох ч мэдээллийг зөвхөн олон нийтийн ашиг сонирхлоос үүдсэн гарцаагүй нөхцөлд ашиглаж болохоор хүрээ хязгаарыг тогтоож өгөх, олон улсын зохих сайн туршлагад үндэслэн хувийн халдашгүй байдал, хувь хүний мэдээллийг хамгаалах нууцлал, хамгаалалтын зохих журам, нэмэлт стандартуудыг мөрдүүлэх шаардлагатай.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Хүний эрхийн хэд хэдэн гэрээгээр хувийн нууцыг хүний үндсэн эрх болохыг тунхагласан байдаг. Тухайлбал “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 17-р зүйлд “Хэнийг ч түүний хувийн байдал, гэр бүл, гэр орон, захидал харилцаанд нь дур зоргоор, эсвэл хууль бусаар хөндлөнгөөс оролцох, нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдаж болохгүй”, цаашилбал “бүх хүн ийм төрлийн хөндлөнгийн оролцоо, халдлагаас хуулиар хамгаалагдах эрхтэй” гэж заажээ.⁴

Хувийн нууцыг хамгаалах талаар Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (12 дугаар зүйл), Хүүхдийн Эрхийн Конвенц (16 дугаар зүйл), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

³ See, e.g., <https://www.thalesgroup.com/en/markets/digital-identity-and-security/government/biometrics/biometric-data> and <https://iapp.org/news/a/processing-biometric-data-be-careful-under-the-gdpr/> discussing the special status of biometric data under the GDPR.

⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 17(1), adopted Dec. 16, 1966, 999 U.N.T.S. 171 [hereinafter ICCPR].

эрхийн тухай конвенцод (22 дугаар зүйл)⁵ мөн дурдсан байдаг. Монгол Улс эдгээр гэрээг болон мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар дурдсан бусад гэрээг соёрхон баталжээ. Мөн түүнчлэн, Европын Холбоо-Монгол Улсын ерөнхий хэлэлцээрт Монгол Улс Европын Холбоотой өгөгдөл хамгааллыг хамгийн өндөр түвшинд хүргэх чиглэлээр хамтран ажиллах үүрэг хүлээсэн байна.

Эдгээрийг нэгтгэн үзэхэд “аливаа улс дотооддоо иргэдийнхээ тухай мэдээлэл цуглуулах” үйл ажиллагаа нь хүний хувийн орон зайд “хөндлөнгийн оролцоо” бий болгож буй нөхцөлд хувийн халдашгүй байдлын эрхийн асуудал хөндөгдөх нь гарцаагүй. Цаашилбал “захидал харилцаа гэх ойлголтод телефон утсаар дамжуулсан мэдээллээс гадна тухайн хүний цахим орчин дахь мэдээлэл мөн багтана гэдэгтэй хэн бүхэн санал нийлэх болсон”.⁶ Хувь хүний халдашгүй байх эрхийн хүрээнд хүн өөрийн хувийн мэдээлэлд нэвтрэх, хяналт тавих эрх хамаарах⁷ бөгөөд улс орон дотооддоо хяналтын зорилгоор иргэдийн мэдээллийг цуглуулж ашиглах үйл ажиллагааны явцад мөн энэ эрх хангагдах учиртай.⁸

Хувийн халдашгүй байх эрх нь хүмүүс өөрсдийн “хувийн орон зай”-д төрийн оролцоогүй харилцаанд орох боломжтой байх үндсэн зарчимд суурилдаг.⁹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “Хувь хүн захидал харилцааны нууцлалаа хадгалах эрхээ эдлэхийн тулд мэдээллээ нууцлах, хамгаалах, хэрэв хүсвэл нэрээ нууцлах боломжтой байх ёстой” гэж хүлээн зөвшөөрсөн байдаг.¹⁰

Бүс нутгийн болон олон улсын байгууллагуудын заавар зөвлөмжид хувийн халдашгүй байх эрх, хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудалтай холбоотой нэмэлт удирдамжийг тусгасан байдаг. Европын Хүний Эрхийн Шүүх (ЕСННР)-ээс тогтоосон прецедентыг авч үзвэл, дээрх эрхэд нөлөөлөх аливаа үйл ажиллагаа нь тухайн нөхцөлд зайлшгүй шаардлагатай буюу тодорхой зорилгод хүрэхээр тодорхойлсон арга зам болохын хувьд тохирохуйц байх ёстой бөгөөд хяналтын зорилгоор мэдээлэл цуглуулж ашиглах ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд хийгдэх ёстой байна.¹¹ Хяналтын зорилгоор мэдээлэл цуглуулж ашиглах үйл ажиллагаа нь зайлшгүй байх, тохирохуйц байх, хууль ёсны байх зарчмуудад заавал нийцэх ёстой талаар олон улсын эрх зүйн бусад хэд хэдэн баримт бичигт тодорхой тусгасан байдаг. Тухайлбал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн “Цахим эринд хувийн халдашгүй байх эрхийг хангах тухай (9/166 (2014))” тогтоолд цахим харилцаа холбоог тагнаж, хянах үйл ажиллагаа

⁵ Хувийн халдашгүй байх эрхийг дараах олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тусгажээ. Үүнд: the Charter of Fundamental Rights of the European Union (Article 7), the Arab Charter on Human Rights (Articles 16 and 21), the American Convention on Human Rights (Article 11), the European Convention of Human Rights (Article 8), and the American Declaration on the Rights and Duties of Man (Article V).

⁶ Ashley Deeks, An International Legal Framework for Surveillance, 55 Virginia J of Intl L: 291, 305 (2015).

⁷ Manfred Nowak, U.N. Covenant on Civil and Political Rights: CCPR Commentary at 388 (2005).

⁸ Deeks, supra note 300, at 311.

⁹ See, Lord Lester and D. Pannick (eds.). Human Rights Law and Practice. London, para. 4. 82 (Butterworth, 2004).

¹⁰ United Nations Human Rights Council, A/HRC/23/40, “Report of UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Frank La Rue” April 17, 2013, para. 23.

¹¹ Marko Milanovic, Human Rights Treaties and Foreign Surveillance: Privacy in the Digital Age, HARV. INT’L L.J. (2015), <http://ssrn.com/abstract=2418485>.

олон нийтэд нээлттэй, ойлгомжтой, тодорхой, аль нэг талыг алагчлаагүй хууль тогтоомжийн хүрээнд, олон улсын хүний эрхийн зарчмуудтай нийцэх байдлаар явагдах ёстой ба хувийн халдашгүй байдалд нөлөөлөх аливаа үйлдэл нь дур зоргын бус, хууль ёсны байх ёстой” гэсэн зарчмыг заажээ.¹² Мөн түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2017 оны “Цахим эринд хувийн халдашгүй байх эрхийг хангах тухай” шинэчилсэн тогтоолд тагнаж хянах үйл ажиллагааг зохицуулахдаа “алдаа мадаггүй процесс, дотоод хяналтын болон маргаан шийдвэрлэх механизм, хувь хүний халдашгүй байх эрх болон бусад эрхэд нөлөөлөх байдал, мөн дур зоргын бус, хууль ёсны байх, зайлшгүй байх, тохирохуйц байх зарчмууд”-ыг заавал анхаарч үзэхийг тусгажээ.¹³

Тэрчлэн НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар (ХЭДК)-ын тайланд хууль тогтоомжийн ойлгомжтой хүртээмжтэй байдал, нууцлалын асуудлын талаар дараах зүйлийг тусгажээ:

Нууц тогтоол дүрэм ба нууц тайлбарууд ...– шүүхийн нууц тайлбаруудыг мөн чанарын хувьд “эрх зүйн баримт бичиг”-ийн шаардлагыг хангаж байна гэж үзэх боломжгүй. Аюулгүй байдал, тагнуулын алба гэх мэт гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад хэтийдсэн эрх мэдэл олгосон хууль, дүрэм журамд ч мөн энэ хамаатай ... Тагнах хянах тодорхой эрх мэдлийн нууцлаг мөн чанар нь тухайн эрх мэдлийг дур зоргоор ашиглах эрсдэлийг дагуулдаг бөгөөд үүнтэй холбоотой нарийн зохицуулалт, нэмэлт хяналт шаардлагатай. ¹⁴

НҮБ-ын ХЭДК-ын тайланд аливаа хянаж тагнах үйл ажиллагааг гүйцэтгэх засаглалын баталсан журмаар бус, парламентаас хэлэлцэж баталсан суурь хууль тогтоомжоор зохицуулах нь сайн туршлага мөн гэсэн байх ба ингэснээр “тагнаж хянах үйл ажиллагааг зохицуулах аливаа хууль тогтоомж нь олон нийтэд нээлттэй байхыг шаардсан Иргэний болон улс төрийн эрхийн пактын 25 дугаар зүйл хэрэгжих боломж нээгдээд зогсохгүй, хууль тогтоомжийг боловсруулах үйл явцад олон нийт оролцох боломж” нээгдэх ач холбогдолтой.¹⁵

Мэдээллийг хамгаалахтай холбоотой Европын холбооноос гаргасан “Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүмүүсийг хамгаалах тухай конвенц”-д тодорхой жишээг дурдсан байдаг. Үүнд, хувийн мэдээллийг автоматаар боловсруулахад “хуулийн хүрээнд, шударгаар цуглуулсан байх, тодорхой бөгөөд хуульд нийцэх зорилгоор хадгалсан байх, зорилгод нийцэхгүй байдлаар ашиглахгүй байх, мэдээллийг хадгалах зорилгод нийцтэй, хамааралтай, хэтийдээгүй байх” болон бусад холбогдох зарчмыг мөрдлөг болгохыг заасан байна.¹⁶ Тэрчлэн хувь хүмүүст

¹² U.N. General Assembly Resolution on the Right to Privacy in the Digital Age, U.N. Doc. A/RES/69/166 (18 December 2014).

¹³ U.N. Human Rights Council Resolution on the Right to Privacy in the Digital Age, U.N. Doc. A/HRC/34/L.7/Rev.1 (22 March 2017).

¹⁴ Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights, The Right to Privacy in the Digital Age, U.N. Doc. A/HRC/27/37 (30 June 2014).

¹⁵ Id.

¹⁶ Convention for the Protection of Individuals with regard to Automatic Processing of Personal Data Strasbourg, 28.I.1981, art 5.

өөртэй нь холбоотой хувийн мэдээлэлд нэвтрэх эрх олгох, шаардлагатай бол эдгээр өгөгдлийг засах, устгах эрхийг олгодог байна.¹⁷ Европын Холбооны Мэдээлэл Хамгаалах Ерөнхий Журам (GDPR)-д хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой зарим зарчим туссан байх бөгөөд мэдээллийг хамгаалах талд илүүтэй ач холбогдол өгсөн зохицуулалт гэж үздэг (гэхдээ олон судлаач тус журмыг цаашид өргөжүүлэх ёстой гэж үздэг).¹⁸

Дээрхээс гадна Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын 2013 онд шинэчилсэн “Хувийн мэдээллийн хил дамнасан урсгал, хувийн мэдээллийг хамгаалах тухай (1980)” удирдамжид мөн нэмэлт зохицуулалтууд байх ба үүнд гишүүн орнуудыг олон улсын гэрээгээр хүлээсэн бусад үүргийн хамт “хүний хувийн халдашгүй байдал болон мэдээллийн чөлөөт урсгалыг хамгаалахад төр засгийн дээд түвшинд манлайлал үзүүлэх, тууштай байгаагаа батлан үзүүлэх”¹⁹-ийг уриалсан байдаг.

Хувь хүний нууцад тавигдах хязгаарлалтууд

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 17-р зүйлд тусгасан хувийн нууц, халдашгүй байх эрхэд зайлшгүй бөгөөд хууль ёсны, тохирох хязгаарлалтыг тавьж болох санаа агуулагдаж байдаг ба НҮБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг сурталчлах, хамгаалах асуудлаарх Тусгай илтгэгч (Тусгай илтгэгч)-ийн илтгэлд хувийн нууцтай холбоотой эрхэд тавигдах хязгаарлалт нь Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар 27, 15-р зүйлд дурдсан чөлөөтэй хөдөлгөөн хийх эрхэд тавигддаг хязгаарлалттай адил хэмжээнд байх нь зүйтэй гэсэн байна. Үүнд:

- (а) Аливаа хязгаарлалт нь хуульд заасан, хуулийн хүрээнд байх ёстой;
- (б) Хүний язгуур эрхэд хамаарах эрхийг хязгаарлалтад хамруулахгүй;
- (в) Аливаа хязгаарлалт нь ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай байх;
- (г) Хязгаарлалтыг хэрэгжүүлэх эрх мэдэлд заавал давхар хяналт тавих;
- (д) Хязгаарлалтын тухайд энэ нь дурдсан хэд хэдэн зорилгын аль нэгэнд хүрэх нь хангалтгүй ба хууль ёсны тодорхой зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай байх ёстой ба,
- (е) Хязгаарлалтын арга хэмжээ нь нөхцөл байдалд тохирсон байх зарчимд нийцсэн, өөрөөр хэлбэл хамгаалах үүргээ хэрэгжүүлэхэд тохирсон байх, боломжит шийдлийн хувилбарууд дотроос хүний хувийн мэдээлэлд хамгийн бага нэвтрэх, хамгаалах ёстой ашиг сонирхолд тохирсон байх гэх мэт болно.²⁰

¹⁷ Id. at art 8.

¹⁸ For some additional commentary, see, e.g., <https://www.nytimes.com/2020/04/27/technology/GDPR-privacy-law-europe.html>, <https://www.theguardian.com/commentisfree/2019/nov/10/these-new-rules-were-meant-to-protect-our-privacy-they-dont-work>.

¹⁹ OECD Guidelines on the Protection of Privacy and Transborder Flows of Personal Data 1980, updated in 2013, <https://www.oecd.org/internet/ieconomy/privacy-guidelines.htm>.

²⁰ Human Rights Committee, General Comment No. 27: Freedom of Movement (Article 12), para. 15, UN Doc # CCPR/C/21/Rev.1/Add.9 (1999); United Nations Human Rights Council, A/HRC/23/40, “Report of UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Frank La Rue” April 17, 2013, para. 29.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн халдашгүй байх эрх нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд “хувийн халдашгүй байх эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай урьдач нөхцөл гэж ойлгоно.”²¹ Эдгээр эрхийн аль нэгийг хязгаарлах нь нөгөө эрхийг хангахад нөлөө үзүүлдэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19-р зүйлд заасан гурван хэсгээс бүрдэх шалгуурыг хангасан байх ёстой бол хувийн халдашгүй байдлын эрхийг хязгаарлахад Ерөнхий тайлбарын 27-д заасан шалгуурыг хангасан байх нь зүйтэй юм.²²

ДҮГНЭЛТ

АТБХОУТ нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн талаар энд толилуулсан товч тайлбарыг өгөх боломжийг олгосонд талархаж байна. Цаашид уг хуулийн төслийг сайжруулж боловсронгуй болгох аваас зохих олон улсын стандарт, сайн туршлагад аль болох дөхүүлж нийцүүлэхийн дээр дотоодын иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр аливаа засвар өөрчлөлт хийхийг зөвлөж байна.

АТБХОУТ-ийн зүгээс шаардлагатай бол бусад шаардлагатай техникийн туслалцаа үзүүлж ажиллахад бэлэн байна.

²¹ United Nations Human Rights Council, A/HRC/23/40, “Report of UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Frank La Rue” April 17, 2013, para. 24.

²² Id. at para. 29.

ICNL INTERNATIONAL CENTER FOR NOT-FOR-PROFIT LAW

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ) нь иргэний нийгмийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгож хөгжүүлэхэд дэлхийн улс орнуудад техникийн туслалцаа, судалгаа шинжилгээ, боловсролын дэмжлэг үзүүлдэг олон улсын байгууллага юм. АТБХОУТ нь дэлхийн 100 гаруй оронд хийгдсэн иргэний нийгмийн эрх зүйн шинэчлэлд туслалцаа үзүүлээд байна. АТБХОУТ нь олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, хувийн сангууд болон дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Бидний үйл ажиллагааны талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг www.icnl.org цахим хуудаснаас үзэх боломжтой.

Энэ удаагийн “Хуулийн шүүмж”-ид Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (www.icnl.org)-өөс 2021 оны I улиралд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас олон нийтэд хэлэлцүүлэхээр цахим хуудсандаа нийтэлсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөлд өгсөн санал шүүмжийг ННФ-аас эрхлэн монгол хэл рүү буулгаснаар хэвлэн нийтлэв.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар-14240
Монгол Улс
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

